



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/621

Номгон

「Худалдан авах ажиллагааг Цагдаагийн
газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /а/ дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хуулийн байгууллагуудын Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор лед дэлгэц нийлүүлэх” 45.000.000 /Дөчин таван сая/ төгрөгийн ажлын худалдан авах ажиллагааг тус газарт эрх шилжүүлж гүйцэтгүүлсүгэй.

2.Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу 10 дугаар сарын 20-ны дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

3.Дээрх 45.000.000 (Дөчин таван сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.“Хуулийн байгууллагуудын Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор лед дэлгэц нийлүүлэх” ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601210449